

“МОНГОЛ УЛСЫН ЭРДЭС БАЯЛГИЙН ГЕОПОЛИТИК: ОРОС, ХЯТАДЫН ХҮЧИН ЗҮЙЛ”

*Д.Шүрхүү**

Монгол Улс хүн амын тоогоор дэлхийд 90-ээс хойгуур бичигдэх жижиг улсад тооцогдох боловч энгүй уудам нутаг дэвсгэрийнхээ хэмжээгээр бол нэлээд дээгүүр эхний 20-д багтах томоохон орнуудын нэг билээ. Дэлхийн хамгийн том нутаг дэвсгэртэй ОХУ, хамгийн их хүн амтай Хятад хэмээх хоёр их гүрний дунд хавчуулагдан орших Монгол улсын хувьд харьцангуй том нутаг дэвсгэр нь геополитикийн болон геозэдийн засгийн үүднээс авч үзвэл улс орны тусгаар тогтнолын хамгийн чухал баталгаа, хүч чадлын үндэс суурь, хөгжлийн чухал эх үүсвэр болох учиртай. Их Монгол улсыг байгуулсан Чингис хааны алдар суугаараа, ардчилал, зах зээлийн систем рүү хийсэн түүхэн шилжилтээрээ дэлхий нийтийн анхаарлыг татаж байсан монгол түмэн XXI зууны эхэнд хосгүй эрдэс баялгаараа хол ойрын улс гүрнүүдийн анхаарал сонирхлыг татах боллоо.

2005 оны байдлаар дэлхийн уул уурхайн салбарт хамгийн их хөрөнгө оруулалтыг татсан 10 орны тоонд Монгол Улс багтсан байна. Anglogold, BHP Billiton, Cameco, Rio Tinto, Mitsui зэрэг уул уурхайн дэлхийн тэргүүлэх компаниуд Монголд хөрөнгө оруулж, үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. Монгол дахь олон улсын хөрөнгийн корпорацийн мэдээлснээр Монголд ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 18 компани Торонтогийн биржид хувьцаагаа гаргадаг байна. Эдгээр компанийн Монголтой хамааралтай хөрөнгийн хэмжээ нь 2.5 тэрбум доллар ажээ.

ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Жеймс Бейкер нарын саяхан Монголд хийсэн айлчлалын үеэр яригдсан гол сэдэв Монголын эрдэс баялаг. Уул уурхайн нөөц баялгийг нээн ашиглах нь хэдийнээ Монгол-Хятадын харилцааны тэргүүлэх чиглэл болж, Монгол Улсын төрийн тэргүүнд БНХАУ-ын дарга Ху Жинтао Төмөртийн овооны цайрын баяжуулах үйлдвэр ашиглалтад орсонтой холбогдуулан захидал ирүүллээ.

Юуны учир Монгол Улсын эрдэс баялаг гадаадынхны шохоорхлыг татах болсон бэ?

1-рт, Монгол Улс газрын хэвлийн геологийн тогтцоороо эрдэс баялгийн нөөц ихтэй орон зай байж болох нь сүүлийн жилүүдийн геологи хайгуулын судалгаа улам бүр нотлож байна. Магадгүй 1997 оны хууль ч үнд гол үүрэг гүйцэтгэсэн байж болох юм. Өөрөөр хэлбэл зэс, жонш, нүүрсийг эс тооцвол Монголын уул уурхайн салбар дөнгөж

* Д.Шүрхүү - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

эхлэлийн шатандаа байгаа гэсэн үг. Монгол улсын газар нутгийн зөвхөн 30 орчим хувьд нь геологийн судалгаа хийгджээ.

2-рт, Монгол Улсын, улмаар ирээдүйтэй ашигт малтмалын ордын газар зүйн байршил. Сүүлийн жилүүдийн судалгаагаар Монгол орны умарт, төв, өмнөд хэсгүүд нь өнгөт металлын хүдэржилтийн хувьд ихээхэн ирээдүйтэйд тооцогдож байна. Тухайлбал тус орны өмнөт болон умарт нутгуудаар зэс-молибдений чиглэлийн хүдрийн томоохон ордууд илрэх магадлал өндөр байна. Зэс болон бусад өнгөт металлын хүдэржилтийн томоохон ордууд байж болох Говь-Алтайн нурууны дагуу эрэл, хайгуулын ажил эрчимтэй хийгдэж байна. Алтайн гэж нэрлэгдэх металлогений мужийн хүрээнд ОХУ, БНХАУ-д хар тугалга-цайрын том хэмжээний ордууд тогтоогдон, ашиглагдаж байгаа ба ОХУ-Монгол Улсын хилийн зааг орчмын нутгаар өнгөт металлын хүдрийн гидротермаль, төмрийн хүдрийн галт уулын гаралтай төрлийн хүдэржилтийн илрэлүүд тогтоогдсон ажээ. Мөн түүнчлэн нүүрс, газрын тос, жонш, фосфорит, алт, мөнгө, газрын ховор элементийн илэрц, ордууд хил орчмын нутаг түлхүү олдож байна. Энэ нь зах зээлд ойр, тээврийн зардал хэмнэх зэрэг олон давуу талтайн зэрэгцээ хөрш орнуудын харилцаанд ихээхэн зэрэг, сөрөг нөлөө үзүүлэх боломжийг агуулж байна.

3-рт, дэлхийн өнгөт металл, эрчим хүчний түүхий эдийн үнэ асар их өсөн нэмэгдэж байна. Манай экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, алт, цайрын үнэ 2006 он гарснаас хойш огцом нэмэгдэж, 4-р сарын 20-ний өдрийн байдлаар Лондонгийн металлын бирж дээр 1 тн зэсийн үнэ 1988 оноос хойш гарсан хамгийн өндөр үнэ 6780 ам.долларт хүрч, 1 унци алтны үнэ 649 ам.доллар болсон нь сүүлийн 25 жилд гараагүй өндөр үнэ юм. Цайрын үнэ 1 тн нь 3 310 ам доллар хүрсэн нь мөн л өндөр үнэ ажээ. Өнгөт металлын эрэлтийн огцом өсөлтөнд дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй хамгийн том эдийн засаг, мөн хамгийн том хэрэглэгчийн нэг болох Хятадын эдийн засгийн өсөлтийн өндөр хурд (2005 онд 9.9%, 2006 оны I улиралд 10.2%, аж үйлдвэр – 18-20%) ихээхэн нөлөө үзүүлж байна.¹ Иймд ойрын ирээдүйд манай уул уурхайн салбараас олборлолт, экспорт нь нэмэгдэх магадлалтай цайр, газрын тос, нүүрс зэрэг ашигт малтмалын үнэ тасралтгүй өсөх хандлагатай байна.

4-рт, улс төр, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал, хууль эрхийн таатай орчин. Монгол Улс ардчилал, зах зээлийн тогтолцоонд амжилттай шилжиж буй, мөн дотоодын шашин омог, үндэстний зөрчил, терроризмын халдлагаас ангид харьцангуй тогтвортой тайван орон. Бас нэг чухал зүйл бол хүн ам цөөтэй тул, байгаль орчныг нь илт сүйтгэхгүй бол бусад талаар орон нутгийн иргэдийн эсэргүүцэл багатай орон. Мөн хөрш орнуудтайгаа найрсаг харилцаатай, газар нутаг, түүхээс улбаалсан болон шашин-үндэстний, газар нутгийн шинжтэй маргаан зөрчилгүй, гадаад орчин таатай орнуудын нэг юм.

Сүүлийн жилүүдийн байдлаас харахад Монгол орны дээрх хүчин зүйлүүдтэй уялдан эрдэс баялгийн ашиглалтыг тойрсон геополитикийн том өрсөлдөөн эхлээд байна. Энэхүү Монголын эрдэс баялгийн геополитикийн тоглоомонд үндсэн гурван тоглогч оролцох нь улам бүр тодорч байна. Энэ бол манай уул уурхайн салбарт нэгэнт тогтоосон хяналт, ашиг сонирхлоо хэвээр хадгалан бэхжүүлэх, шинэ өрсөлдөгч орж ирэхээс ихэд болгоомжилж буй ОХУ, жил байтугай, сар өдрөөр эрдэс баялгийн эрэлт хэрэгцээ нь өсч, эрчим хүч, аж үйлдвэрийн гол гол түүхий эдийн хувьд улам бүр гадаад зах зээлээс хараат болж буйн улмаас нөөцөө задалж буй Монгол Улсыг улам бүр чухалчлан үзэх болсон БНХАУ, хэрэв нөхцөл бололцоо, үнийн таатай орчин бүрдсэн тохиолдолд ашигт малтмалын хосгүй баялаг нөөц, шинэ ордууд руу хөрөнгө оруулахад ямагт бэлэн байдаг гуравдахь орны болон үндэстэн дамнасан уул уурхайн аварга том компаниуд болон том ордын эрэлд мордсон уул уурхай дунд, жижиг (junior) компаниуд юм.

Манай улсын эрдэс баялгийн геополитикт голлох үүрэг гүйцэтгэх хоёр хөрш БНХАУ, ОХУ-ын бодлого, үйл ажиллагаа, ашиг сонирхол чухамд юунд чиглэж буйг тодруулах үүднээс зарим тоо баримт, мэдээллийг хүргэе.

БНХАУ. Хятад улсын эрчим хүчний болон аж үйлдвэрийн түүхий эдийн импорт жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Синьхуа агентлагийн уламжилснаар 2005 онд үндсэн 5 төрлийн эрдэс түүхий эдийн импорт 378.7 тэрбум ам.доллар болсон нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 0.8 хувь өсч, нийт импортын дүнгийн 26.6 хувийг эзлэх болжээ.²

Хятадын худалдааны танхимын төлөөлөгчийн үзэж байгаагаар эдийн засгийн түргэн хөгжил эрдэс баялгийн эрэлт нийлүүлэлтийн зөрчлийг улам хурцатгаж, импортоос хараат байдлыг нэмэгдүүлж байгаа ажээ. Хятад улсын Газар, нөөц баялгийн яамнаас гаргасан статистикийн мэдээгээр 2005 онд тус улс 2.19 тэрбум тн нүүрс, 181 сая тн газрын тос, 421 сая тн төмрийн хүдэр, 352 сая тн ган, 16.3 сая тн 10 төрөл өнгөт төмөрлөг олборлосон байна. Харин 2005 онд Хятад улс 126.8 сая тн газрын тос, 275.2 сая тн төмрийн хүдэр, 4.58 сая тн марганцын хүдэр, 3,02 сая тн хром, 4,06 сая тн зэсийн хүдэр импортоор авчээ.³

Иймд эрчим хүч, аж үйлдвэрт нэн шаардлагатай эрдэс, түүхий эдийн найдвартай эх үүсвэр олох, тогтвортой хангах асуудал Хятадын төрийн бодлогын хамгийн томоохон зорилтуудын нэг, улс орны эдийн засгийн аюулгүй байдалтай холбогдсон амин чухал эрх ашгийн асуудал болж байна.

2005 онд Хятадад 169 том болон дунд ашигт малтмалын орд илрүүлсний 40 нь түлш, эрчим хүчний, 44 нь өнгөт металлын, 11 нь үнэт металлын ордууд байв. Үүний үр дүнд газрын тос, байгалийн хий, нүүрс, төмөр зэрэг ашигт малтмалын нөөц нэмэгдэж, харин хром, зэс, цайрын нөөц нь буурсан ажээ.⁴ Хятад улс дотоодын нөөц бололцоог

нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрдэс түүхий эдийн гадаад эх үүсвэрээ бэхжүүлэх талаар идэвхитэй ажиллаж байна. Юуны өмнө эрчим хүч, түүхий эдийн нөөц баялаг ихтэй орнууд, тухайлбал ОХУ, Казахстан, Чили, Австрали, Саудын Араб, Иран, Нигери, Венесуэл зэрэг орнуудтай харилцаагаа идэвхижүүлж байна. Энэхүү дипломат бодлогын үр дүнд Хятадын уул уурхайн компаниудыг дэлхийн тавцанд гаргах, юуны өмнө томоохон орд газруудад хөрөнгө оруулах, хувьцааны багцыг худалдаж авах, хамтарсан компаниуд байгуулах зэрэг чиглэлд хөрөнгө санхүү, хүч анхаарлаа төвлөрүүлж байна.

Сүүлийн жилүүдэд Хятадын газрын тосны томоохон компаниуд (CNPC, CNOOC) засгийн газрын хүчтэй дэмжлэг, улсын зээлээр Индонез, Австрали, Венесуэл, Ангол зэрэг олон орны газрын тос, байгалийн хийн хувьцааг худалдан авах олон тэрбум долларын гэрээг байгуулсан байна. Өнгөрсөн жил CNPC 4.2 тэрбум доллараар Казахстаны томоохон газрын тосны ордыг (Petrokazakhstan) компаниас худалдан авчээ. CNOOC мөн энэ оны эхээр Нигерийн газрын тосны ордын хувьцааны 45 хувийг 2.7 тэрбум доллараар авах гэрээ хэлцэл хийж эхэлсэн байна. Харин CNOOC нь өнгөрсөн зун АНУ-ын UNOCAL компанийг авахын тулд Chevron (16.6 тэрбум ам.доллар)–оос бараг 2 тэрбум илүү санал тавьсан боловч АНУ зүгээс үндэсний аюулгүй байдал болон Ази дахь нөлөөнд хохиролтой хэмээн үзэж Хятадын компанид зарахыг зөвшөөрөөгүй билээ.⁵

Хятад улс хилийн чанад дахь эдийн засгийн үйл ажиллагаагаа идэвхижүүлэх, гадагшаа хөрөнгө оруулах, гадаадын томоохон компани болон уул уурхай, газрын тос, хийн том ордуудыг авах болсны чухал үндэс суурь тус орны валютын нөөц ихээхэн зузаарч байгаатай холбож болох юм. Хятадын ардын банкны мэдээлснээр 2006 оны 3-р сарын сүүлчийн байдлаар Хятад улсын валютын нөөц 875,1 тэрбум ам.долларт хүрчээ.⁶ БНХАУ энэ үзүүлэлтээр бүр 2-р сард Японыг гүйцэж түрүүлэн дэлхийд тэргүүлэх болсон бөгөөд эдийн засагчдын тооцоолсноор оны сүүлч гэхэд нэг триллион ам.доллараас давж мэдэх ажээ. Япон улс гуравдугаар сарын сүүлч гэхэд 852 тэрбум ам.долларын нөөцтэй байсан байна.

Хятад улс Монголын хамгийн том хөрөнгө оруулагч. Хөрөнгө оруулалтын хувьд гэвэл, 1990 оноос 2004 оны эцэс хүртэл 73 орны 3042 үйлдвэр аж ахуйн нэгж Монголд 1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулжээ. Хятадаас 1601 үйлдвэр, аж ахуйн нэгж Монголд 457 сая ам.долларын хөрөнгө оруулсан нь Монголын гадаад хөрөнгө оруулалттай нийт үйлдвэр, аж ахуйн газрын 34.8%, хөрөнгө оруулалтын 37.9%-ийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд Хятадын хөрөнгө оруулалт уул уурхайн чиглэлээр эрс нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд 2006

онд зөвхөн газрын тосны салбарт Хятадын компаниуд 102.7 сая ам.долларын хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

БНХАУ-ын “Доншен газрын тос Монгол” 2003 оны 3 дугаар сард Австралийн “РОК Ойл” компанийн, АНУ-ын “СОКО Тамсаг Монголиа ЛЛС” компани нь 2005 оноос гэрээлэгчийн эрхийг БНХАУ-ын “Петро Чайна Дачин Тамсаг Монгол”-д 100 хувь шилжүүлэн өгчээ. Ингэснээр Монголын газрын тосны идэвхитэй хайгуул, олборлолт хийж буй орд газрууд бүгд Хятадын компаниудын мэдэлд орсон байна.

ОХУ. Сүүлийн жилүүдэд ОХУ-ын эдийн засгийн хөгжил нэлээд тогтвортой, хурдцын хувьд хөгжингүй орнуудаас дээгүүр, Хятад, Энэтхэгээс арай доогуур түвшинд байна. ИТАР-ТАСС агентлагийн мэдээлснээр ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамны сайд Г.Греф тус орны дотоодын нийт бүтээгдэхүүн 1999-2005 онд 1.5 дахин буюу 196 тэрбум ам.доллараас 765 тэрбум ам.доллар болтлоо өссөн хэмээн мэдэгджээ. Гэхдээ сайдын үзэж байгаагаар ОХУ өнгөрсөн жилүүдийн өсөлтийн гол хүчин зүйл болох газрын тос хийний эрчимтэй хөгжил, рублийн ханшны доогуур ханшны гүйцэтгэх үүрэг, нөөц бололцоо шавхагдаж байгаа тул цаашид хөгжлийг түргэтгэх гол боломж, гарц бол хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх (диверсификаци) явдал хэмээн онцлон тэмдэглэжээ. Ойрын жилүүдэд газрын тосны үнэ огцом өсч, эрчим хүчний эх сурвалжийн төлөөх дэлхийн хэмжээний өрсөлдөөн, сөргөлдөөн улам ширүүсэх хандлагатай боллоо. ОХУ нь дэлхийн байгалийн хийн нөөцийн 26.7%, олборлолтын 22.1%, экспортын 29%, газрын тосны нөөцийн 6%, олборлолтын 11.4%, экспортын 9.3% эзэлдэг томоохон нийлүүлэгчийн хувьд эрчим хүчний хүчтэй дипломат бодлого явуулж байна.⁷ Стратегийн өрсөлдөгчдийн зарим нь ОХУ-ын нөлөө өсөхөөс ихэд болгоомжилж, зарим нь харилцаагаа улам ойртуулан нягтруулахыг зорьж байна. Энэхүү хоёр үйл явцыг харуулсан жишээ бол 2006 оны 3-р сард ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин 2006 оны 6-р сард Санкт-Петербургт болох Их наймын уулзалтанд зориулж бичсэн өгүүлэл, мөн БНХАУ-д түүний хийсэн айлчлалууд юм. В.Путин энэхүү өгүүлэлдээ, дэлхийн эрчим хүчний аюулгүй байдлыг хангах стратеги боловсруулах нь онцгой чухал гэж бид үзэж байна. Экспортлогч орнууд болон хэрэглэгчдийн аль алиных нь санаанд нийцсэн үндэслэлтэй үнээр эрчим хүчээ урт хугацааны туршид, найдвартай, экологийн хувьд хүлээн авч болохуйцаар хангах зарчмыг дэвшүүлсэн билээ. Үүний гол зорилго бол мөргөлдөөнөөс, эрчим хүчний хангамжийн төлөө тэмцлийн оновчтой бус хэлбэрээс хамгаалах, дэлхийн эрчим хүчний тийм “архитектур”-ыг хойч үедээ үлдээх явдал ажээ.⁸

ОХУ хэдийгээр 1990 оноос хойш Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй бага (2003 оны байдлаар 380 үйлдвэр, аж

ахуйн нэгж, 7.8 сая ам.долларын хөрөнгө оруулсан) боловч манай улсын уул уурхайн гол үйлдвэрүүд болох “Эрдэнэт”, “Монросцветмет” компаниудад гол хөрөнгө оруулагч, мөн манай улсын түлш шатахууны импортыг бараг 100 хувь нийтлүүлдэгийн хувьд, цаашдаа уул уурхайн салбарт ОХУ-ын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа зэргээс харахад ОХУ-ын Монголд дахь ашиг сонирхол нөлөө бүхий, жинтэй хэвээр байгаа болно.

Монгол Улсын эрдэс баялаг тойрсон геоздийн засаг, геополитикийн өрсөлдөөн нь манай орон, манай ард түмний сайн сайхан, хөгжил цэцэглэл, аюулгүй байдалд хэр зэрэг нөлөө үзүүлэх вэ, бид тэрхүү өрсөлдөөнд хэрхэн оролцох вэ гэдэг асуудал хүн бүхний анхаарал сонирхлыг татаж байна. Монголчууд өөрийн газрын хэвлий дэх ашигт малтмалаа малтан авах нь дотоод, гадаадын цөөн хэдэн уул уурхайн компаний эрхэлдэг, эдийн засаг, экологийн асуудал төдий биш, харин Монголын гадаад харилцаа, аюулгүй байдлын хамгийн чухал, хамгийн эмзэг асуудал болох нь жилээс жилд тодорч байна.

Гадаад ертөнцийн зүгээс тавих болсон энэхүү анхаарал сонирхол, өрсөлдөөний сайн тал гэвэл Монгол орны, түүний дотор уул уурхайн салбарын нэр хүнд өсч, бидний хүсэн хүлээдэг гадаадын хөрөнгө оруулалт тал бүрээс урсан ирж, манай орны эдийн засгийн чадавхи өсөн нэмэгдэж, ард түмний аж байдал сайжрах явдал гэдэгтэй маргах хүн байхгүй болов уу.

Гэвч байгалийн эрдэс баялаг нөөц улс орныг, ард түмнийг шууд баян чинээлэг болгох хөгжил цэцэглэлийг авчирдаггүй болохыг манай орноос өмнө энэ замыг туулж өнгөрүүлсэн улс орнуудын гашуун туршлага бэлхнээ харуулж байна. Эл асуудлыг орон орны нэртэй эрдэмтэн судлаачид, эдийн засагчид нягтлан судалж, олон зуун бүтээл туурвилдаа заан тэмдэглэсэн байна. Тухайлбал, Нобелийн шагналт, америкийн нэртэй эдийн засагч Жозеф Е. Штиглиц (Joseph E. Stiglitz) баялаг сөрөг үр дагаварт хүргэх хэд хэдэн хүчин зүйл байдаг тухай онцлон тэмдэглэжээ. Үүнд: Эхний асуудал нь улс, орнууд баялаг гэж нэрлэдэг зүйл дээрээ мэхлүүлдэг явдал байна. Дараагийн асуудал нь баялгаас цөөн тооны хүмүүс ашиг хонжоо олох, түүнийг өөрийн болгохоор бүх арга, хэрэгслийг ашигладаг явдал. Үүний үр дүнд нийгэм бүхэлдээ хохирол амсдаг. Дараагийн нэг асуудал бол байгалийн баялаг ихтэй орнууд түүнээсээ хэт хамааралтай болж, үнийн маш их тогтворгүй байдал бий болдог бөгөөд энэ нь эдийн засгийн ихээхэн хор холбогдолтой. Дөрөв дэх нь олон улсын банкууд байдлыг бүр дордуулдаг явдал юм. Тав дахь асуудал нь голланд өвчин. Энэ нь товчоор хэлэхэд баялгийг засгийн газрууд зөвхөн ойр, зуурын ашиг олоход ашигладаг, үүний үр дүнд баялаг урт хугацааны тогтвортой хөгжилд хүргэдэггүй явдал юм.⁹

Байгалийн эрдэс баялгийн ашиг орлогын хуваарилалтыг ил тод, шударга байдлаар хуулийн дагуу шийдвэрлэхгүй бол ялангуяа стратегийн чухал түүхий эд, хосгүй арвин ордууд дотоодод улс төрийн

зөрчил тэмцэл, зэвсэгт мөргөлдөөн, бүр төрийн эргэлтэнд хүргэж байсан гашуун туршлага түүхэнд зөндөө байна. Холын жишээ гэвэл манай улсын нэгэн адил зэсээр байн орон болох Чилид 1973 онд гарсан төрийн эргэлт гадаадын хөрөнгө оруулалттай 4 том зэсийн уурхайг улс нийгэмчилсэнтэй багагүй холбоотой билээ. Мөн ойрын жишээ бол ОХУ-д “Юкос” компанитай холбогдсон хэрэг явдал тус орны улс төрийн амьдралд маш их нөлөөлсөн билээ.

Монголын эрдэс баялгийг ашиглахтай тойрсон геополитикийн өрсөлдөөнд бид амжилттай оролцохын тулд, хөрш БНХАУ, ОХУ-ын зүгээс ирэх сөрөг нөлөөлөл, учирч болзошгүй дарамт шахалтаас зайлсхийхийн тулд дараахь зүйлүүдэд онцгой анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

1. Уул уурхай дахь гадаадын хөрөнгө оруулалт, түүний дотор лиценз олгох асуудал Монгол Улсын ирээдүйн хувь заяа, эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц асуудал хэмээн маш анхаарал болгоомжтой хандах. Өнөөгийн байдлаар хөрш хоёр орон (ОХУ-248, БНХАУ-232) эзэмшиж буй лицензийн тоогоороо, оруулсан хөрөнгө оруулалтаараа тэргүүлж яваагийн хувьд ашиг сонирхлоо хамгаалах шаардлага гарвал улс төр дипломатын хүчтэй шахалт үзүүлэх магадлал өндөр байна. Цаашид ч энэ улсуудын цэрэг, эдийн засгийн хүч чадал, дэлхийн бодлогод эзлэх байр суурь есөхийн хэрээр энэ аюул занал нэмэгдэх боломжтой.

2. Уул уурхайн бүтээгдэхүүн олборлолт, ялангуяа хөрөнгө хамтарсан, дангаар хөрөнгө оруулсан компанитай байгуулах гэрээ хэлэлцээрийн биелэлт, түүний дотор хилийн ойролцоо олборлолт явуулж буй уурхайнуудаас хилээр орж гарч буй бүтээгдэхүүний тоо хэмжээ, хүн машин техникийн хөдөлгөөнд хяналт тавих механизмыг боловсронгуй болгож, хяналтыг олон талаас үр дүнтэй болгох шаардлагатай байна.

3. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортлох үнэ, ялангуяа нүүрс, цайр, төмрийн хүдэр гэх мэт нийтэд төдийлөн таньж мэдэгдээгүй ашигт малтмалын үнийг, цаашид нийт экспортын үнийг хянан зохицуулах механизм бий болгох, эсвэл Эрдэс баялгийн зөвлөлийн эрх хэмжээг өргөтгөн, зөвхөн нөөц батлах бус ашигт малтмалын үнэ ханш, найрлага, тоо хэмжээнд хяналт тавьдаг болгон өөрчлөх,

4. Эрдэс баялгийн олборлолтын үр ашгийг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах үүднээс аль болох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх. Үүний тулд алт, зэсийн үнийн өсөлтөөс орж ирэх нэмэлт орлого (цаашид бусад улс орнуудын жишгээр ашигт малтмалын бүх төрөлд нөөцийн рентгийн татвар буюу хэт өндөр ашгийн татвар тогтоох), ноогдол ашиг, бусад орлогуудын нэлээд хувийг Тогтворжилтын сангаар дамжуулан зэс хайлуулах үйлдвэрийг оновчтой газарт гадаадын хамтарсан үйлдвэрийн байдлаар байгуулж, зэсийн баяжмалыг хяналтандаа авах, баяжмалыг шууд экспортлох тохиолдолд тодорхой хэмжээний татвар ноогдуулах. Мөн түүнчлэн хөрш орнуудаас гарч буй төслүүд (ОХУ-1.5

сая тн газрын тос боловсруулах үйлдвэр, БНХАУ-ын Шэнхуа компаний нүүрс гүн боловсруулах санал)-ийг хэрэгжүүлэх,

5. “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага”-д Монгол Улс нэн даруй тууштай нэгдэн орох хэрэгтэй байна. Уг санаачлагын дагуу компаниуд, түүний дотор одоо хэвлэл мэдээллийн хэрэгслээр ихээхэн шуугиан дэгдээж буй хөрш орнуудын компаниудтай засгийн газар, манай компаниудын байгуулсан бүх гэрээ, засгийн газарт хийсэн бүх төлбөр нээлттэй болж, иргэд байгалийн баялгаас орсон орлогыг мэдэж, тэрхүү орлогыг хэрхэн зарцуулж байгааг мэдэж авах боломжтой болж, улмаар нийгмийн дунд хүчтэй буй хардлага, сэрдлэг, болгоомжлол буурах боломжтой. Ингэснээр иргэний болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирч, нийгмийн хяналт дээшилж, тэр хэмжээгээр нийгмийн бухимдал буурна.

6. Гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаа уул уурхайн салбарын хөгжилтэй нягт холбох, үүний тулд Зэс, Жонш, Нүүрс, Эрчим хүчний гэх мэт хөтөлбөр боловсруулж, тэр чиглэлийн дипломат бодлого боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Хөрөнгө оруулалт, ялангуяа хил орчмын томоохон уул уурхайн төслүүдэд дэлхийн нөлөө бүхий их гүрнүүд, уул уурхайн томоохон компаниудыг түлхүү оруулах асуудлыг онцлон авч үзэх хэрэгтэй бөгөөд энэ нь улс орны тусгаар тогтнол, хил хязгаарын аюулгүй байдалд стратегийн чухал ач холбогдолтой болохыг анхаарах зэрэг болно.

Хэрэв төрийн зөв бодлого, хуулийн зөв зохицуулалт, зөв менежмент, зөв хуваарилалт хийхгүй бол улс орны улс төр, эдийн засаг, экологийн аюулгүй байдалд ноцтой аюул учрах, ялангуяа их гүрнүүд, үндэстэн дамнасан корпорациудын өрсөлдөөн, зөрчилдөөнд татагдан орох магадлал өндөр байна.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. <http://quote.bloomberg.com/apps/news>. Copper, Zinc, Silver Soar, Leading Rebound in Demand for Metals.
2. <http://news.xinhuanet.com/english/> 2006-04-14
3. 2005 оны Хятад улсын газар, нөөц баялгийн тухай албан мэдээ
4. Мөн тэнд
5. Central Asia-Caucasus Analyst, 27 July 2005
6. <http://news.xinhuanet.com/english/> 2006-04-14
7. Эх сурвалж: BP (2004) Statistical Review of World Energy. June 2004, London BP
8. Зууны мэдээ. 2006-03-07 №52-53
9. Хөгжил ба байгалийн баялаг. www.opensocietyforum.mn